Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XXIX.3	III. Тоног төхөөрөмж			24,800.0	1,685.8
	<i>Шилжих</i>			<i>24,800.0</i>	<i>1,685.8</i>
XXIX.3.1	Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх "Хур" систем /Улсын хэмжээнд/	2019	2022	23,000.0	585.8
XXIX.3.2	Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй болгох "Олон талт түншлэл" цахим хөтөлбөр /Орхон/	2021	2022	1,800.0	1,100.0
XXX	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД			15,634.1	1,000.0
XXX.1	I. Барилга байгууламж			15,634.1	1,000.0
	<i>Шинэ</i>			<i>15,634.1</i>	<i>1,000.0</i>
XXX.1.1	"Алтанбулаг" чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн өргөтгөл /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2022	2024	15,634.1	1,000.0
	НИЙТ			6,292,735.7	1,957,656.2

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

УЛААНБААТАР ХОТ

2022 он

Агуулга

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	3
1.1. Эдийн засгийн ерөнхий төлөв	3
2. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19) ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	5
3. НЭГДСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ	7
3.1. Төсвийн тодотгол хийх үндэслэл, баримтлах үндсэн зарчмууд	7
3.2. Төсвийн орлого	8
3.3. Төсвийн зарлага	9
3.4. Төсвийн хөрөнгө оруулалт, баримтлах зарчим	10
3.5. Гадаад зээл, тусламж	11
3.6. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд	11
4. МАКРО ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ	12

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

1.1. Эдийн засгийн ерөнхий төлөв

Дэлхий нийтэ сүүлийн хоёр жилийн хугацаанд коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөлөөгөөр эрүүл мэнд болон эдийн засгийн хүндхэн сорилтуудтай нүүр тулгарч байна. Харин 2022 онд дэлхийн хэмжээнд вакцинжуулалт эрчимжиж, цар тахлын хүрээ хумигдсанаар улс орнуудын хөл хорио, хязгаарлалт буурч, эдийн засаг сайжрах төлөвтэй байна.

Засгийн газрын хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний үр дүнд вакцинжуулалт шуурхай хийгдэж, ААН-үүдэд бага хүүтэй зээл олгож ажлын байрыг хадгалж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүллээ.

Цаашид Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө” үргэлжлэх болон “Шинэ сэргэлтийн бодлого” хэрэгжиж эхлэх тул 2022 онд дэвшүүлсэн эдийн засгийн зорилтуудад хүрэх боломжтой байна.

Эдийн засгийн өсөлт

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2021 оны 3 дугаар улиралд 29.6 их наяд төгрөгт хүрч, эдийн засаг өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өслөө.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар

	2018	2019	2020	2021
	Жил бүрийн эхний 3 улирал			
Эдийн засгийн өсөлт	7.0	6.8	-6.7	3.6
Хөдөө аж ахуй	4.4	1.2	10.8	-4.7
Уул уурхай	1.3	6.4	-22.1	11.7
Боловсруулах/үйлд	13.5	2.6	-5.8	6.4
Цахилгаан, хий	7.6	5.2	1.1	9.1
Барилга	-3.7	16.8	-1.9	-37.4
ББЖХ	2.4	14.4	-14.8	8.2
Тээвэр	14.1	10.9	-23.6	-8.2

Мэдээлэл, холбоо	14.5	13.3	5.5	10.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5.1	4.7	-3.0	2.4
Цэвэр татвар	23.0	10.8	-8.8	14.9


Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Аж үйлдвэрийн салбар 4.2 хувиар, үйлчилгээний салбар 3.2 хувиар өссөн хэдий ч коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын нөлөөгөөр хилийн боомтууд дээр хүндрэл үүсэж түүхий эдийн экспорт саатаж байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлах эрсдэлтэй байна.

Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эцсийн байдлаар 16.1 тэрбум ам.долларт хүрч 2020 оноос 25.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай байна.

График 1. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт, импорт, тэнцэл /тэрбум ам.доллар/



Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар

Экспортоор 9.2 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь 2020 оноос 22.1 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Үүнд уул уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Импортоор 6.8 тэрбум ам.долларын бараа, түүхий эд худалдан авсан нь өмнөх оноос 29.4 хувиар өсжээ. Импортын өсөлтөд тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги, химийн бүтээгдэхүүн, машин механизм, тоног төхөөрөмж, ургамлын гаралтай

бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний өсөлт голлон нөлөөлсөн байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл 2021 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 436 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Урсгал ба хөрөнгийн данс 986 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 869 сая ам.долларын ашигтай гарсан байна.

График 2. Төлбөрийн тэнцэл /сая ам.доллар/



Эх үүсвэр: Монголбанк


Гадаад валютын улсын нөөц 11 дүгээр сарын эцсийн байдлаар 4,165 сая

ам.доллар байгаа нь импортын 7.3 сарын хэрэгцээг хангаж, “хүрэлцээт” түвшинд байна.

Инфляц

Инфляц 2021 оны эцэст 13.4 хувь хүрлээ. Тээвэр, логистикийн түгжрэл, тээврийн зардлын өсөлт, бусад улс орнуудын инфляц зэрэг нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйл инфляцад голлон нөлөөлж байна.

График 3. Инфляцын бүтэц /хувь/



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Энэ нь Монголбанкны зорилгод түвшин (6 хувь \pm 2 нэгж хувь)-с давсан байна.

2. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19) ЦАР ТАХЛЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ



Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас дэлхий нийтийг хамарсан **COVID-19** коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэнд, амьжиргаа, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, эдийн засгийн хүндрэлээс сэргийлж, эрчимжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг 2020 оноос эхлэн үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна. Өнгөрсөн онуудад иргэдэд үзүүлсэн халамж, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт болон бусад арга хэмжээнд 2020 онд 2.5 их наяд төгрөг, 2021 онд 4.4 их наяд төгрөг буюу нийт **6.9 их наяд** төгрөгтэй тэнцэх хэмжээний арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.



Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх "10 их наядын цогц төлөвлөгөө"-г 2021 оны 2 сараас эхлэн авч хэрэгжүүлсэн. Энэхүү бодлогын хүрээнд 2021 онд ажлын байрыг дэмжих зээлийн хүрээнд 2.0 их наяд төгрөг, ипотекийн зээл 1.0 их наяд төгрөг, репо санхүүжилт 825.0 тэрбум төгрөг, хөдөө аж ахуйг дэмжих зээл 494.0 тэрбум төгрөг буюу нийт 4.4 их наяд төгрөгийг 62.7 мянган аж ахуй нэгжид олгож, 315 мянган ажлын байрыг хадгалж, 111 мянган ажлын байрыг шинээр бий болголоо.

Хүснэгт 2. Коронавируст халдвар (Ковид-19)-ийн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	Нийт дүн
Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн 100,000 төгрөг	2,532.2
Хатуу хөл хорионы үед иргэн бүрт 300,000 төгрөг	1,100.0
Хувийн хэвшлийн ААН, байгууллагад ажиллаж байгаа даатгуулагч болон	863.4

сайн дурын даатгуулагчийн НДШ-ийг бүтэн болон тусгай хувиар чөлөөлсөн	
Айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан болон дулааны эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцсан	745.4
Халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн тэтгэмжийг тус бүр 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн	420.6
Эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг нэмэгдүүлсэн	354.0
Хувь хүний орлогын албан татвараас 6 сарын хугацаанд чөлөөлсөн	209.4
Айл өрхийн болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны төлбөрийг төрөөс хариуцсан	120.1
Жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогыг 6 сарын хугацаанд орлогын албан татвараас чөлөөлсөн	116.9
Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас сэргийлэх “Дархлаажуулалтын аян”-д хамрагдсан иргэн бүрт 50,000 төгрөг	110.0
Хүнсний голлох бүтээгдэхүүний гаалийн албан татвар, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн	79.7
Эрүүл мэндийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвар, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн	72.5
Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн хүнсний талоны үнийг 2 дахин нэмэгдүүлсэн	55.4
Татварыг ногдуулж тайлагнасан боловч хуулийн хугацаанд төлөөгүй тохиолдолд тооцох алданги, торгуулийг нэг удаа чөлөөлсөн	48.2
Үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгжийн ажилтнуудад 3 сарын хугацаанд сар бүр 200,000 төгрөг	44.2

Айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлсөн	18.0
Зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай	3.5
түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан бол орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлсэн	
Нийт	6,903.5



Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдэл нь байгаа онож ядуурлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байна. 2020 оны 4-р сараас 2021 оны 12-р сарыг дуустал хугацаанд хэрэгжсэн хүүхдийн мөнгийг нийт 1.2 сая хүүхдэд сар бүр 100 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн арга хэмжээнд нийт **2.5 их наяд** төгрөг зарцуулсан байна. Дэлхийн банкнаас хийсэн судалгаагаар цар тахлын үед Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлсэн нь ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад хамгийн эерэг нөлөө үзүүлсэн арга хэмжээ болсон ба нийт өрхийн бага орлоготой 40 хувьд өндөр нөлөөлөл үзүүлсэн гэж дүгнэсэн байна.



Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай чөлөөлж, хөнгөлснөөр 2020-2021 онд нийт аж ахуйн нэгж, даатгуулагч нийтдээ 873.4 тэрбум төгрөгийг өөртөө авч үлдсэн байна. Цар тахлын эхэн үед буюу 2020 онд аж ахуй нэгж байгууллагын ажилтан болон сайн дурын даатгуулагчийг НДШ төлөх үүргээс зургаан сарын хугацаанд чөлөөлж, мөн гурван сарын хугацаанд буюу 2020 оныг дуустал 5 хувь болгож хөнгөлсөн билээ. Хөнгөлөлтийн арга хэмжээг үргэлжлүүлж 2021 оны 7 дугаар сарын 1 хүртэл 8.5 хувь

болгож хөнгөлсөн бөгөөд энэ арга хэмжээнд 523.9 мянган даатгуулагч хамрагдсанаар 2021 онд 160.2 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдөж байна.

Хүснэгт 3. Цар тахлын үед НДШ-ийн хувь хэмжээнд хийсэн зохицуулалт /тэрбум төгрөг/

Үе шат	Төлөх НДШ	ААН, даатгуулагчид үлдсэн
2020. IV-X	0 %	566.3
2020. X-XII	5 %	146.9
2021. I-VII	8.5%	160.2
Нийт		873.4



Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, малын тэжээлийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж байна. Цар тахлын үед хүнсний бүтээгдэхүүний хомсдол, үнийн зохиомол хөөсрөлт үүсэхээс сэргийлэх зорилгоор 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардлагатай малын тэжээлийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн байна. Арга хэмжээний үр дүнд 2020 онд 143 аж ахуйн нэгжийн импортолсон хүнсний бүтээгдэхүүнийг **31.2 тэрбум** төгрөгийн татвараас, 2021 онд 196 аж ахуйн нэгжийн импортолсон хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээлийг **48.5 тэрбум** төгрөгийн татвараас чөлөөлсөн байна.



Цахилгаан, дулааны эрчим хүч, хогны төлбөрийг төр хариуцан төлөх шийдвэр нь айл өрх, ААН-ийн зардлыг бодитойгоор бууруулж орлогыг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалахад чухал хувь нэмэр болж байна. 2020 оны 12 сарын 1-ний

өдрөөс айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төрөөс хариуцан төлөхөөр шийдвэрлэсэн. Энэхүү төрөөс хариуцах цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн санхүүжилтэд нийт **883.5 тэрбум** төгрөг зарцуулсан байна.



Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг тогтоосон болон вакцинжуулалтын үеэр иргэдэд олгосон дэмжлэг,

урамшуулал нь цар тахлын тархалтыг хязгаарлаж, дархлаажуулалтыг богино хугацаанд явуулахад чухал ач холбогдолтой болсон. 2021 оны 4 дүгээр сард коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед Монгол Улсын иргэн бүрт 300 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгоход **1.1 их наяд** төгрөг зарцуулав. 2021 оны 5 дугаар сард коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын эсрэг вакцины эхний тунд хамрагдсан 2.2 сая насанд хүрэгчдэд 50 мянган төгрөгийн урамшуулал олгоход **110 тэрбум** төгрөг тус тус зарцуулаад байна. Вакцины эхний тунгаа хийлгэсэн иргэдэд урамшуулал олгож эхэлсэн нь вакцинд хамрагдалтыг богино хугацаанд өндөр хувьтай гарахад нөлөөлсөн байна.

3. НЭГДСЭН ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ

3.1. Төсвийн тодотгол хийх үндэслэл, баримтлах үндсэн зарчмууд

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал нөлөөгөөр дэлхий нийт болон Монгол Улс сүүлийн хоёр жилийн хугацаанд эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг, төсвийн хүндхэн сорилтуудыг даван туулж байна. Цар тахлын үеийн эрсдэлийг даван туулахын тулд 2020-2021 онд Засгийн газраас иргэдээ вакцинжуулах, иргэдийн орлого, ажлын байрыг хамгаалах, аж ахуйн нэгж, бизнесийг дэмжихэд чиглэсэн нийт 6.9 их наяд төгрөгийн цогц арга хэмжээг төсвөөс үе шаттай хэрэгжүүллээ.

Үүний үр дүнд 2021 оны 3 дугаар улиралд эдийн засаг 3.6 хувиар өсөж, 2021 оны жилийн эцэст экспортын орлого түүхэндээ анх удаа 9.2 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Монгол Улсын 2021 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн

нийт орлогын төлөвлөгөө 102.7 хувийн биелэлттэй, үүнээс нийгмийн даатгалын сангийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 322.3 тэрбум төгрөгөөр давж биелжээ. Улмаар дотоодын нийт бүтээгдэхүүний 8.8 хувьтай тэнцүү байхаар батлагдсан төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлын хэмжээ 1.9 пунктээр сайжирч 6.9 хувьд хүрсэн эерэг үзүүлэлттэй байна.

Улсын Ерөнхийлөгчөөс ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой шийдлийг дотоод нөөц бололцоогоо дайчлан яаралтай боловсруулж, үе шаттай авч хэрэгжүүлэн ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосон. Иймд Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг үндэслэн 2022 оны улсын төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсөвт тодотгол хийх замаар Нийгмийн даатгалын сангийн 2021 оны давсан орлогын эх

үүсвэрийг ашиглан ахмадуудын тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлэхээр тооцсон төсвийн зохицуулалт хийх саналаа танилцуулж байна.

Энэхүү төсвийн зохицуулалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нэгдсэн төсвийн орлого, зарлага ба алдагдлын нийт хэмжээг өөрчлөхгүйгээр, төсвийн тусгай шаардлагыг баримтлан

төсвийн тогтвортой байдлыг хангах замаар хэрэгжүүлэх болно.

Тэтгэвэр нэмэх арга хэмжээнд шаардагдах төсвийн зохицуулалтыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны батлагдсан төсвийн урсгал зардлаас 49.6 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зардлаас 260.4 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламжаас 30.0 тэрбум төгрөг, нийт 340.0 тэрбум төгрөг бууруулах замаар хэрэгжүүлэхээр төлөвлөлөө

Төсвийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг төслийн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан.

- 34.1.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх;
- 34.1.2. Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх;
- 34.1.3. Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн;
- 34.1.4. Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх;
- 34.1.5. Хууль болон гэрээнд зааснаар Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд Засгийн газрын өрийн баталгааны хөрөнгө хүрэлцэхгүй болсон.

3.2. Төсвийн орлого

3.2.1. Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл

Дэлхий нийтийг хамарсан коронавируст цар тахлын хүнд үед Монгол Улсын Засгийн газар иргэдийнхээ эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, бизнесийн орчныг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, нэг удаагийн дэмжлэг тусламж, цахилгаан, дулаан, хог, усны төлбөрийг төрөөс даах багц арга хэмжээ, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө зэрэг мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлсэн.

Улмаар 2021 оны 3 дугаар улирлын байдлаар эдийн засаг 3.6 хувиар, жилийн эцэст гадаад худалдааны эргэлт өмнөх оноос 25 хувиар өссөн байна. Үүний үр дүнд Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 14.2 их наяд төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 2.7 хувиар давж биелсэн байна.

Татварын бааз суурийг хамгаалж, татвар хураалтыг сайжруулснаар 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 2.4 их наяд төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 196

тэрбум төгрөгөөр, иргэдийн орлогыг нэмэгдүүлснээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2.3 их наяд төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 376.9 тэрбум төгрөгөөр тус тус давсан нь орлогын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Хүснэгт 4. 2021 оны нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл

Үзүүлэлт	2021 төлөв	2021 гүйц	Зөрүү
Нийт орлого	13,877.8	14,255.2	377.4
Тогтворжуулалтын сан	612.8	627.9	15.1
Ирээдүйн өв сан	1,062.4	937.9	-124.4
Тэнцвэржүүлсэн орлого	12,202.5	12,689.3	486.7
Татварын орлого	10,682.7	11,262.7	580.0
Татварын бус орлого	1,519.8	1,426.6	-93.2

3.2.2. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлогыг 16.4 их наяд төгрөг байхаар тооцсон. Үүнээс 643.4 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлнэ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дагуу тооцсон тэнцвэржүүлсэн нийт орлого 2022 онд 15.8 их наяд төгрөгт хүрэхээр байна.

3.3. Төсвийн зарлага

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд оруулах өөрчлөлтийн тухай хуульд Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд дараах зохицуулалтын арга хэмжээг тусгалаа. Үүнд : Коронавируст халдвар (Ковид-19) цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, цагдаа, онцгой байдал,

Хүснэгт 5. 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого

Үзүүлэлт	тэрбум ₮
Нийт орлого ба тусламжийн дүн	16,415.1
Тогтворжуулалтын сан	643.4
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	15,771.7
Татварын орлого	13,941.3
Татварын бус орлого	1,830.4

Засгийн газраас 2022 онд Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлж эдийн засгийг дэмжих, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, боомтын нэвтрэх чадварыг сайжруулах, худалдааг хөнгөвчлөх, төрийн өмчийн хуулийн этгээдийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэн Монгол Улсын 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Харин коронавируст халдвар (Ковид-19)-ын шинэ хувилбарууд гарч байгаагийн улмаас үүсч буй нийгэм, эдийн засгийн тодорхойгүй байдал 2022 онд улс орнуудад үргэлжлэх төлөвтэй байна. Үүнтэй холбогдуулан гадаад худалдааны эргэлт саарах, экспорт буурч төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна.

гааль, хил хамгаалах байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага зэрэг салбараас бусад ерөнхийлөн захирагчдын зарцуулах 4.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвтэй арга хэмжээний зардлыг 10.1 хувиар бууруулахаар тооцлоо.

3.4. Төсвийн хөрөнгө оруулалт, баримтлах зарчим

3.4.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2022 онд



Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт **2,218.1** тэрбум төгрөгийн **1426** төсөл, арга хэмжээ, концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн **7** төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд **303.6** тэрбум төгрөг, нийт **2,521.7** тэрбум төгрөгийн **1433** төсөл, арга хэмжээ батлагдсан.

Нийт хөрөнгө оруулалтын 82.5% нь буюу 1.8 их наяд төгрөг нь дэд бүтэц, бүтээн байгуулалт, барилга байгууламжийн санхүүжилт:

График 4. Улсын төсвийн хөрөнгийн зардал /тэрбум төгрөг



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийгмийн ач холбогдол бүхий эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээг төлөвлөж, дараах зарчмын дагуу хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, олон жил үргэлжилж байгаа төслүүдийг ашиглалтад оруулах, шинээр хэрэгжүүлэх төслүүдийн худалдан авах ажиллагааг 2022 оны 3 дугаар

сарын 1-ний дотор зохион байгуулж дуусгах;

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүжилтийн шуурхай, нээлттэй, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан хангах, төсвийн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарч ажиллах;
- Шинэ төрлийн коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын тархалттай холбоотойгоор эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг тэргүүн ээлжинд санхүүжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг иргэдэд хурдан шуурхай хүргэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх;
- Концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийн санхүүжилтийг хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтэд үндэслэн олгож байх бодлогыг баримталж байна.

3.4.2. Төсвийн тодотголд улсын төсвийн хөрөнгө оруулалтын баримтлах зарчим

1/ 2022 онд хэрэгжихээр батлагдсан нийт 1433 төслийн 1-ээс бусад ямар ч төслийг хасахгүй;

2/ 2022 онд дуусах төслүүдийг хөндөөгүй, зөвхөн дараа он руу үргэлжлэн хэрэгжиж байгаа зарим төслүүдээс

тодорхой санхүүжилтийг нь 2023 он руу шилжүүлэх зохицуулалт хийх;

3/ Төслүүдийн дуусах хугацааг хойшлуулахгүй;

4/ Өнгөрсөн 2021 оны хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэл 72 хувьтай гарсан байна. Өмнөх жилүүдийн гүйцэтгэлийн дундаж

үзүүлэлттэй харьцуулан санхүүжилтийг ирэх жилүүд рүү шилжүүлэх зэрэг болно.

Ингэснээр нийт 123 төсөл арга хэмжээнд хамаарах 260.4 тэрбум төгрөгийн санхүүжилтэд зохицуулалт хийхээр байна. Энэ нь батлагдсан 2.5 их наяд төгрөгийн санхүүжилтийг 10.3 хувиар бууруулах болно.

3.5. Гадаад зээл, тусламж



Монгол Улсын 2022 оны төсөвт гадаадын төслийн зээл, тусламжийн ашиглалт **1,682.5** тэрбум төгрөгөөр батлагдсан бол 2022 оны төсвийн тодотголд нийт **1,652.5** тэрбум төгрөгийн зээл, тусламжийг авч ашиглахаар төлөвлөгдлөө.

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тодотголын төсөлд дараах зарчмыг баримталсан. Үүнд:

✓ Нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг үргэлжлэн санхүүжүүлэх;

✓ Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх төслүүдийг дэмжих, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлийн төслүүдийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх;

✓ 2022 онд дуусах төслүүдийн санхүүжилтийг бүрэн олгох, үргэлжлэн хэрэгжиж буй төслүүдийн санхүүжилтийг ажлын гүйцэтгэлийг

үндэслэн санхүүжүүлэх ба дараах төслүүдийн санхүүжилтийг бууруулахаар төлөвлөсөн. Үүнд:

- 2022 онд эхлүүлэхээр төлөвлөн гэрээ байгуулагдах шатандаа байгаа боловч коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдлаас удаашралтай байгаа төслүүд;
- Зээлийн хэлэлцээр байгуулагдсан боловч бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажил эхлэх бэлтгэл, хугацаа болоогүй төслүүд;
- Коронавируст халдвар (Ковид-19)-ын нөхцөл байдлаас шалтгаалан ажил нь удаашрах магадлалтай төслүүд;
- Мөн төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас цуцлах санал ирүүлж, зээлдүүлэгч талаас зөвшөөрсөн төслүүд.

Үүний үр дүнд 2022 оны төсвийн тодотголоор нийт гадаад төслийн зээлийн ашиглалт **30.0** тэрбум төгрөгөөр буурч тооцогдсон.

3.6. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Дээрхи өөрчлөлтүүдийн үр дүнд нэгдсэн төсвийн нийт орлого 16.4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 18.1 их наяд төгрөг ба тэнцвэржүүлсэн

алдагдал 2.4 наяд буюу ДНБ-ны 5.1%-тай тэнцэж, нийт орлого болон нийт зарлага өөрчлөгдөөгүй тул Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн

тусгай шаардлагуудыг бүрэн хангаж байна.

Хүснэгт 6. Нэгдсэн төсвийн үзүүлэлт /тэрбум төгрөг/

	Бат-2022	Тод-2022	Зөрүү
НИЙТ ОРЛОГО	16,415.1	16,415.1	-
Тогтворжуулалтын сан	643.4	643.4	-
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	15,771.7	15,771.7	-
НИЙТ ЗАРЛАГА	18,158.8	18,158.8	-
Урсгал зардал	13,226.3	13,516.6	-290.4
Хөрөнгийн зардал	5,197.1	4,906.7	290.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-264.6	-264.6	-
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-2,387.1	-2,387.1	-
ДНБ-д эзлэх хувь	-5.1%	-5.1%	-

4. МАКРО ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

1 *Коронавируст халдвар (Ковид-19)-ын шинэ хувилбарууд үүсэх улмаар дэлхийн эдийн засгийн уналт удаан үргэлжлэх.*

Коронавируст халдварын (Ковид-19) мутацид орсон шинэ хувилбарууд бий болж байгаа нь дэлхий нийтээр тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна. Дэлхийн эдийн засагт сэргэлт бий болж байгаа ч цар тахлын үргэлжлэх хугацаа, дэлхийн 2022 оны эдийн засагт үзүүлэх хор уршгийн хэмжээ тодорхойгүй, цаашид халдварын давлагаа дахин гарч болзошгүй эрсдэл хэвээр байна. Энэ нь эдийн засгийн өсөлт төсөөлснөөс бага гарах эрсдэлийг дагуулж байна.

2 *Цаг агаарын хүчин зүйлс болон малын гоц халдвар өвчний тархалтаас шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарах.*

Хур тунадасны хэмжээ 2022 онд олон жилийн дунджаас өндөр байх, хаваржилт хүндрэх тохиолдолд хөдөө аж ахуйн салбарын өсөлт, бүтээмж төсөөлсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна. Мөн 2022 оны 1 дүгээр сарын байдлаар 16 аймагт малын гоц халдварт шүлхий өвчний голомт бүртгэгдсэн байгаа нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж, хүнсний бүлгийн үнийг хөөрөгдөх хор уршигтай байна.



ДАГАЛДАХ ХУУЛИУД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар
сарын ... өдөр

Улаанбаатар хот

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.2.Энэ хуулийн 7.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “2022 оны 06 дугаар сарын 30-ны” гэснийг “2022 оны 12 дугаар сарын 31-ний” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр” гэснийг “нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсөв хооронд, ” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Улсын Их Хурал 2021 оны 6 дугаар сарын 29-ны өдөр Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж уг хуулийн 7.2 дахь заалтыг “Энэ хуулийн 7.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу тухайн жилийн төсөвт тодотгол хийх замаар Улсын Их Хурлаар шийдвэрлүүлнэ” гэж өөрчлөн найруулсан. Ингэснээр өмнө нь мөрдөж байсан “Энэ хуулийн 7.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөнө.” гэсэн зохицуулалт өөрчлөгдсөн байна.

Хүн амыг цар тахлын эсрэг вакцинжуулах арга хэмжээ эрчимтэй явагдаж байгаа боловч Ковид-19-ын мутацид орсон шинэ хувилбарууд бий болж байгаа нь дэлхий нийтээр тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна

Иймд цар тахлын үргэлжлэх хугацаа, дэлхийн 2022 оны эдийн засагт үзүүлэх хор уршгийн хэмжээ тодорхойгүй, цаашид халдварын давлагаа дахин гарч болзошгүй эрсдэл хэвээр байгааг харгалзан цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх агуулга бүхий хуулийн 7.1.2 дахь заалтыг хэрэгжүүлдээ өмнө байсан зохицуулалтыг сэргээх буюу асуудлыг төсөвт тодотгол хийхгүйгээр богино хугацаанд шуурхай шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж хуулийн төсөл боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал нөлөөгөөр дэлхий нийт болон Монгол Улс сүүлийн хоёр жилийн хугацаанд эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг, төсвийн хүндхэн сорилтуудыг даван туулж байна. Цар тахлын үеийн эрсдэлийг даван туулахын тулд 2020-2021 онд Засгийн газраас иргэдээ вакцинжуулах, иргэдийн орлого, ажлын байрыг хамгаалах, аж ахуйн нэгж, бизнесийг дэмжихэд чиглэсэн нийт 6.9 их наяд төгрөгийн цогц арга хэмжээг төсвөөс үе шаттай хэрэгжүүллээ.

Үүний үр дүнд 2021 оны 3 дугаар улиралд эдийн засаг 3.6 хувиар өсөж, 2021 оны жилийн эцэст экспортын орлого түүхэндээ анх удаа 9.2 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна. Монгол Улсын 2021 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 102.7 хувийн биелэлттэй, үүнээс нийгмийн даатгалын сангийн орлого төлөвлөсөн хэмжээнээс 322.3 тэрбум төгрөгөөр давж биелжээ. Улмаар дотоодын нийт бүтээгдэхүүний 8.8 хувьтай тэнцүү байхаар батлагдсан төсвийн тэнцвэржүүлсэн алдагдлын хэмжээ 1.9 пунктээр сайжирч 6.9 хувьд хүрсэн эерэг үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ахмад настны тэтгэврийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тодорхой шийдлийг дотоод нөөц бололцоогоо дайчлан яаралтай боловсруулж, үе шаттай авч хэрэгжүүлэн ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгоод байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг үндэслэн 2022 оны улсын төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсөвт тодотгол хийх замаар Нийгмийн даатгалын сангийн 2021 оны давсан орлогын эх үүсвэрийг ашиглан ахмадуудын тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлэхээр тооцсон болно.

Энэхүү төсвийн зохицуулалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан нэгдсэн төсвийн орлого, зарлага ба алдагдлын нийт хэмжээг өөрчлөхгүйгээр, төсвийн тусгай шаардлагыг баримтлан төсвийн тогтвортой байдлыг хангах замаар хэрэгжүүлэх болно.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн зарлагын хэмжээнд оруулах өөрчлөлтийг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар цар тахлын цаг үед тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлж, өндөр настай иргэдийн амьжиргааг дэмжих эерэг үр дагавартай.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуультай холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5 дугаар зүйл. 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	3,050,964.7
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	2,746,792.7
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	171,464.2
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	36,617.5
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	63,727.6
	1.5 Үйл ажиллагааны урсгал зардал	32,362.7
Нийт зарлага		3,050,964.7

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

НДС-ийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Халдварт цар тахлын үед иргэдийг вакцинжуулах, эдийн засгийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2021 оны нэгдсэн төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсвийн нийт орлого 98.8 хувь, орон нутгийн төсвийн нийт орлого 102.9 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 105.3 хувийн биелэлттэй гарсан бол нийгмийн даатгалын сан 112.8 хувийн биелэлттэй буюу 322.3 тэрбум төгрөгөөр давсан байна.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын Ерөнхийлөгчөөс төсвийн боломжид нийцүүлэн иргэдийн тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосон.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Засгийн газарт өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх боломж нь нийгмийн даатгалын сангийн 2021 оны давсан орлогын эх үүсвэрийг ашиглах явдал бөгөөд үүний тулд 2022 оны улсын төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсөвт тодотгол хийх шаардлага үүсэж байна.

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д “төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх” тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсөвт тодотгол хийх тооцооллыг боловсрууллаа.

Нийгмийн даатгалын сангийн 2021 оны давсан орлогын эх үүсвэрт тааруулан 2022 оны 2 дугаар сарын 1-ээс эхлэн бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 50 мянган төгрөгөөр, бусад тэтгэврийг 20.0-40.0 мянган төгрөгөөр, 2022 оны 10 дугаар сарын 1-ээс бүрэн тэтгэврийн доод хэмжээг 100 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 50.0 мянган төгрөгөөр, бусад тэтгэврийг 20-110 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх тооцооллыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран боловсрууллаа.

Ингэснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500.0 мянган төгрөгт, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 400.0 мянган төгрөгт хүрч тус тус нэмэгдэхээр байна.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсөв тодотгол хийснээр халдварт цар тахлын үед эдийн засгийг сэргээх бодлогын үр дүнд бий болсон нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрийг хуульд заасан төсвийн макро үзүүлэлтийг өөрчлөхгүй, төсвийн тусгай шаардлагыг зөрчихгүйгээр Төсвийн тухай хуульд нийцүүлэн тэтгэвэр нэмэгдүүлэхэд зарцуулах боломжтой болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



4.ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД

	2022 тод төсөл							
	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ			Орон нутаг	НДС	ЭМДС	Ирээдүйн өв сан
		НИЙТ	Төсвөөс санхүүжих	Гадаад зээл, тусламжаас санхүүжих				
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	16,415,107.0	10,049,997.7	9,751,478.3	298,519.4	2,968,968.7	2,840,418.8	1,450,723.5	1,461,737.7
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	643,389.3	643,389.3	643,389.3					
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	15,771,717.7	9,406,608.4	9,108,089.0	298,519.4	2,968,968.7	2,840,418.8	1,450,723.5	1,461,737.7
1. Татварын орлого	13,941,329.3	7,612,407.3	7,612,407.3	0.0	2,284,219.4	2,379,466.3	1,450,723.5	1,057,206.9
1.1. Орлогын албан татвар	2,926,019.4	1,188,630.0	1,188,630.0	0.0	1,737,389.4	0.0	0.0	0.0
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	1,149,199.4	0.0	0.0	0.0	1,149,199.4	0.0	0.0	0.0
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	1,776,820.0	1,188,630.0	1,188,630.0	0.0	588,190.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын орлого	2,987,495.7	0.0	0.0	0.0	0.0	2,379,466.3	1,450,723.5	0.0
1.3. Хөрөнгийн албан татвар	213,444.0	0.0	0.0	0.0	213,444.0	0.0	0.0	0.0
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,441,800.0	3,441,800.0	3,441,800.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	1,132,200.0	1,132,200.0	1,132,200.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	17,200.0	17,200.0	17,200.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	1,081,912.0	1,081,912.0	1,081,912.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	2,141,258.2	750,665.3	750,665.3	0.0	333,386.0	0.0	0.0	1,057,206.9
2. Татварын бус орлого	1,830,388.4	1,794,201.2	1,495,681.8	298,519.4	684,749.3	460,952.6	0.0	404,530.8
2.1. Нийтлэг татварын бус орлого	1,531,698.5	979,540.4	979,540.4	0.0	194,449.2	0.0	0.0	404,530.8
2.2. Хөрөнгийн орлого	170.5	0.0	0.0	0.0	170.5	0.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	298,519.4	298,519.4	0.0	298,519.4	0.0	0.0	0.0	0.0
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	516,141.4	516,141.4	0.0	490,129.6	460,952.6	0.0	0.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,158,797.2	11,786,996.3	10,134,476.9	1,652,519.4	2,968,968.7	2,952,864.7	1,344,969.2	1,461,737.7
А. УРСГАЛ ЗАРЛАГА	13,516,658.8	8,271,516.8	8,034,997.4	236,519.4	1,607,809.8	3,050,964.7	1,481,369.2	1,461,737.7
1. Бараа, үйлчилгээний зардал	4,076,731.9	2,958,926.6	2,729,407.1	229,519.5	966,600.1	31,552.7	254,471.5	0.0
1.1. Цалин, хөлс	1,476,300.2	1,287,258.7	1,278,792.2	8,466.5	165,132.6	19,104.3	4,804.6	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.0	110,969.9	110,969.9	0.0	20,866.4	2,318.0	664.8	0.0
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	2,600,431.7	1,560,698.1	1,339,645.1	221,053.0	780,601.1	10,130.5	249,002.1	0.0
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	959,309.9	959,309.9	959,309.9	0.0	46,821.9	0.0	0.0	0.0
3. Татаас ба урсгал шилжүүлэг	8,480,617.0	4,353,280.3	4,346,280.4	6,999.9	594,387.7	3,019,411.9	1,226,897.7	1,461,737.7
3.1. Татаас	453,491.6	790,789.7	790,789.7	0.0	55,248.3	0.0	67,306.2	0.0
3.2. Урсгал шилжүүлэг	8,027,125.3	3,562,490.6	3,555,490.7	6,999.9	539,139.4	3,019,411.9	1,159,591.5	1,461,737.7
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,906,738.5	3,545,579.6	2,409,579.6	1,136,000.0	1,361,158.9	0.0	0.0	0.0
1. Барилга байгууламж	2,955,069.4	2,920,821.4	1,947,669.1	973,152.3	34,248.0	0.0	0.0	0.0
2. Их засвар	142,368.2	102,368.2	92,810.3	9,558.0	40,000.0	0.0	0.0	0.0
3. Тоног төхөөрөмж	353,976.3	353,976.3	220,776.9	133,199.5	0.0	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө	1,447,244.9	160,333.9	140,243.6	20,090.3	1,286,910.9	0.0	0.0	0.0
5. Стратегийн нөөц хөрөнгө	8,079.7	8,079.7	8,079.7	0.0	0.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	-264,600.1	-30,100.1	-310,100.1	280,000.0	0.0	-98,100.0	-136,400.0	0.0
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-544,600.1	-310,100.1	-310,100.1	0.0	0.0	-98,100.0	-136,400.0	0.0
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	280,000.0	280,000.0	0.0	280,000.0	0.0	0.0	0.0	0.0
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	-2,387,079.4	-5.1%	-2,380,387.9	-1,026,387.9	-1,354,000.0	0.0	-112,445.8	105,754.3
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,387,079.4	2,380,387.9	1,026,387.9	1,354,000.0	0.0	112,445.8	-105,754.3	0.0
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-500,000.0	-506,691.5	-1,419,085.4	912,393.8	0.0	112,445.8	-105,754.3	0.0
2. ЗГ-ын үнэт цаас	1,401,318.6	1,401,318.6	1,802,084.0	-400,765.4	0.0	0.0	0.0	0.0
2.1. Урт хугацаат	1,401,318.6	1,401,318.6	1,802,084.0	-400,765.4	0.0	0.0	0.0	0.0
2.1.1. Дотоод	1,802,084.0	1,802,084.0	1,802,084.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.1.1. Шинээр гаргах	3,696,292.3	3,696,292.3	3,696,292.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.1.2. Үндсэн төлбөр	-1,894,208.3	-1,894,208.3	-1,894,208.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.2. Гадаад	-400,765.4	-400,765.4	0.0	-400,765.4	0.0	0.0	0.0	0.0
2.1.2.1. Шинээр гаргах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.2.2. Үндсэн төлбөр	-400,765.4	-400,765.4	0.0	-400,765.4	0.0	0.0	0.0	0.0
3. ЗГ-ын зээл	842,371.6	842,371.6	0.0	842,371.6	0.0	0.0	0.0	0.0
3.2. Гадаад	842,371.6	842,371.6	0.0	842,371.6	0.0	0.0	0.0	0.0
3.2.1. Төслийн зээл	549,371.6	549,371.6	0.0	549,371.6	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.1. Шинээр авах	1,354,000.0	1,354,000.0	0.0	1,354,000.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.2. Үндсэн төлбөр	-804,628.4	-804,628.4	0.0	-804,628.4	0.0	0.0	0.0	0.0
3.2.2. Хөтөлбөрийн зээл	293,000.0	293,000.0	0.0	293,000.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.2.1. Шинээр авах	293,000.0	293,000.0	0.0	293,000.0	0.0	0.0	0.0	0.0
4. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	643,389.3	643,389.3	643,389.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
5. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	46,805,479.2							

	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ	НДС	ЭМДС	ОРОН НУТАГ
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	35.07	21.47	6.07	3.10	6.34
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	1.37	1.37	0.00	0.00	0.00
ИРЭЭДҮЙН ӨВ САН	0.00	0.00	0.00	0.00	0.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	33.70	20.10	6.07	3.10	6.34
1. Татварын орлого	29.79	16.26	5.08	3.10	4.88
1.1. Орлогын албан татвар	6.25	2.54	0.00	0.00	3.71
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	2.46	0.00	0.00	0.00	2.46
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	3.80	2.54	0.00	0.00	1.26
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.00	0.00	0.00	0.00	0.00
1.2. Нийгмийн даатгалын орлого	6.38	0.00	5.08	3.10	0.00
1.3. Хөрөнгийн албан татвар	0.46	0.00	0.00	0.00	0.46
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	7.35	7.35	0.00	0.00	0.00
1.5. Онцгой албан татвар	2.42	2.42	0.00	0.00	0.00
1.6. Тусгай зориулалтын орлого	0.04	0.04	0.00	0.00	0.00
1.7. Гаалийн албан татвар	2.31	2.31	0.00	0.00	0.00
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	4.57	1.60	0.00	0.00	0.71
2. Татварын бус орлого	3.91	3.83	0.98	0.00	1.46
2.1. Нийтлэг татварын бус орлого	3.27	2.09	0.00	0.00	0.42
2.2. Хөрөнгийн орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
2.3. Тусламжийн орлого	0.64	0.64	0.00	0.00	0.00
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	1.10	0.98	0.00	1.05
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38.80	25.18	6.31	2.87	6.34
А. УРСГАЛ ЗАРЛАГА	28.88	17.67	6.52	3.16	3.44
1. Бараа, үйлчилгээний зардал	8.71	6.32	0.07	0.54	2.07
1.1. Цалин, хөлс	3.15	2.75	0.04	0.01	0.35
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.00	0.24	0.00	0.00	0.04
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	5.56	3.33	0.02	0.53	1.67
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	2.05	2.05	0.00	0.00	0.10
3. Татаас ба урсгал шилжүүлэг	18.12	9.30	6.45	2.62	1.27
3.1. Татаас	0.97	1.69	0.00	0.14	0.12
3.2. Урсгал шилжүүлэг	17.15	7.61	6.45	2.48	1.15
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10.48	7.58	0.00	0.00	2.91
1. Барилга байгууламж	6.31	6.24	0.00	0.00	0.07
2. Их засвар	0.30	0.22	0.00	0.00	0.09
3. Тоног төхөөрөмж	0.76	0.76	0.00	0.00	0.00
4. Бусад хөрөнгө	3.09	0.34	0.00	0.00	2.75
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.02	0.02	0.00	0.00	0.00
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	-0.57	-0.06	-0.21	-0.29	0.00
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-1.16	-0.66	-0.21	-0.29	0.00
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.60	0.60	0.00	0.00	0.00
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	-5.10	-5.09	-0.24	0.23	0.00
ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	46,805,479.2	46,805,479.2	46,805,479.2	46,805,479.2	46,805,479.2

	/сая төгрөг/									/ДНБ-д эзлэх хувь/											
	2015		2016		2017		2018		2019		2020		2021		2022		2022		2022		
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Тод	Бат	Тод төс	Зөрүү	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Тод	Бат	Тод төс	
	-1.	-2.	-3.	-4.	-5.	-6.	-7.	-8.	-9.	-8.	-9.	-8.	-1.	-2.	-3.	-4.	-5.	-6.	-7.	-8.	-9.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,983,397.7	5,835,043.8	7,958,264.6	10,172,760.3	12,040,327.3	10,444,166.6	13,731,670.0	16,415,107.0	16,415,107.0	0.0	25.8	24.4	29.3	31.6	32.6	28.3	32.6	35.1	35.1		
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	2,333.7	0.0	325,680.2	206,986.6	94,596.6	66,242.9	612,800.0	643,389.3	643,389.3	0.0	0.0	0.0	1.2	0.6	0.3	0.2	1.5	1.4	1.4		
ИРЭЭДҮЙН ӨВ САН	0.0	0.0	357,722.8	620,693.6	1,040,219.9	914,085.5	1,062,430.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1.3	1.9	2.8	2.5	2.5	0.0	0.0		
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,981,064.0	5,835,043.8	7,274,861.6	9,345,080.1	10,905,510.8	9,463,832.2	12,056,440.0	15,771,717.7	15,771,717.7	0.0	25.8	24.4	26.8	29.1	29.6	25.6	28.6	33.7	33.7		
1. Татварын орлого	5,118,979.4	4,950,950.2	6,315,131.9	8,217,776.1	9,813,195.8	8,511,605.1	10,625,916.3	13,941,329.3	13,941,329.3	0.0	22.1	20.7	23.2	25.6	26.6	23.0	25.2	29.8	29.8		
1.1. Орлогын албан татвар	1,170,831.3	1,043,368.7	1,613,192.8	2,091,089.9	2,555,734.1	2,227,324.1	3,013,309.3	2,926,019.4	2,926,019.4	0.0	5.1	4.4	5.9	6.5	6.9	6.0	7.2	6.3	6.3		
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	482,334.5	523,410.0	601,047.9	814,158.5	895,161.6	828,851.0	1,002,409.0	1,149,199.4	1,149,199.4	0.0	2.1	2.2	2.4	2.5	2.4	2.2	2.4	2.5	2.5		
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	688,498.8	519,958.7	962,144.9	1,276,931.4	1,660,572.5	1,398,473.1	2,010,900.3	1,778,820.0	1,778,820.0	0.0	3.0	2.2	3.5	4.0	4.5	3.8	4.8	3.8	3.8		
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үний өсөлтийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,018,152.9	1,109,757.4	1,321,375.2	1,638,321.1	2,030,515.3	1,586,015.3	1,896,283.0	2,987,495.7	2,987,495.7	0.0	4.4	4.6	4.9	5.1	5.5	4.3	4.5	6.4	6.4		
1.3. Хөрөнгийн албан татвар	86,610.1	104,659.9	131,129.6	141,225.4	154,369.1	154,876.6	175,714.0	213,444.0	213,444.0	0.0	0.4	0.4	0.5	0.4	0.4	0.4	0.4	0.5	0.5		
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,049,588.7	1,140,721.4	1,618,492.1	2,195,907.2	2,486,268.1	2,208,953.7	2,208,953.7	3,441,800.0	3,441,800.0	0.0	4.5	4.8	6.0	6.8	6.7	6.0	6.7	7.4	7.4		
1.5. Онцгой албан татвар	592,323.6	630,124.8	519,721.5	754,440.2	863,406.5	776,886.3	879,200.0	1,132,200.0	1,132,200.0	0.0	2.6	2.6	1.9	2.3	2.3	2.1	2.1	2.4	2.4		
1.6. Тусгай зориулалтын орлого	11,791.8	10,767.4	12,386.6	13,063.7	16,355.0	17,071.7	15,000.0	17,200.0	17,200.0	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
1.7. Гаалийн албан татвар	320,594.9	328,490.6	512,351.2	682,218.2	790,178.4	740,742.4	930,030.0	1,081,912.0	1,081,912.0	0.0	1.4	1.4	1.9	2.1	2.1	2.0	2.2	2.3	2.3		
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	869,086.2	583,060.0	586,482.8	711,510.3	916,369.2	799,733.0	907,380.0	2,141,258.2	2,141,258.2	0.0	3.8	2.4	2.2	2.2	2.5	2.2	2.2	4.6	4.6		
2. Татварын бус орлого	867,084.7	884,093.5	959,729.8	1,117,304.0	1,092,315.1	1,430,523.7	1,830,388.4	1,830,388.4	1,830,388.4	0.0	3.7	3.7	3.5	3.5	3.0	2.6	3.4	3.9	3.9		
2.1. Нийтлэг татварын бус орлого	753,507.1	805,424.9	896,708.4	1,027,675.0	1,003,117.3	784,979.7	1,279,823.5	1,531,698.5	1,531,698.5	0.0	3.3	3.4	3.3	3.2	2.7	2.1	3.0	3.3	3.3		
2.2. Хөрөнгийн орлого	55,137.9	1,487.3	1,187.9	1,123.6	823.3	1,219.1	400.0	170.5	170.5	0.0	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
2.3. Тусламжийн орлого	53,439.6	77,181.3	61,833.5	88,505.4	88,374.4	166,034.3	150,300.2	298,519.4	298,519.4	0.0	0.2	0.3	0.2	0.3	0.2	0.4	0.4	0.6	0.6		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЭЗЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)	7,137,973.9	9,495,332.9	9,017,318.6	9,317,220.8	11,661,700.9	13,904,273.0	15,748,277.1	18,158,797.2	18,158,797.2	0.0	30.8	30.8	33.2	29.0	31.6	37.6	37.4	38.8	38.8		
A. УРСГАЛ ЗАРЛАГА	5,718,373.8	6,613,809.1	7,043,161.7	7,350,338.9	8,228,578.8	10,828,926.2	12,983,669.6	13,226,261.6	13,516,658.8	290,397.2	24.7	27.7	25.9	22.9	22.3	29.3	30.8	28.3	28.9		
1. Бараа, үйлчилгээний зардал	2,801,673.1	3,133,289.2	3,141,432.3	3,327,510.9	4,000,463.5	4,851,187.0	4,751,390.6	4,075,415.1	4,076,731.9	1,316.8	12.1	13.1	11.6	10.3	10.8	13.1	11.3	8.7	8.7		
1.1. Цалин, хөлс	1,709,772.9	1,746,794.8	1,800,434.6	1,878,939.8	2,256,967.2	2,648,895.0	2,494,086.7	1,467,833.7	1,476,300.2	8,466.5	7.4	7.3	6.6	5.8	6.1	7.2	5.9	3.1	3.2		
1.2. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,091,900.2	1,386,494.4	1,340,997.7	1,448,571.1	1,743,496.3	2,202,292.2	2,257,304.0	2,607,581.4	2,600,431.7	-7,149.7	4.7	5.8	4.9	4.5	4.7	6.0	5.4	5.6	5.6		
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	731,055.1	986,099.8	1,156,465.1	1,046,419.8	860,980.8	939,200.6	965,523.5	959,309.9	959,309.9	0.0	3.2	4.1	4.3	3.3	2.3	2.5	2.3	2.0	2.0		
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,185,645.6	2,494,420.0	2,745,264.2	2,976,408.1	3,367,134.5	5,038,558.5	7,266,755.4	8,191,536.6	8,480,617.0	289,080.4	9.4	10.4	10.1	9.3	9.1	13.6	17.2	17.5	18.1		
3.1. Татаас	101,482.0	229,325.3	280,619.2	230,028.7	298,900.8	375,070.7	401,504.3	437,945.4	453,491.6	15,546.2	0.4	1.0	1.0	0.7	0.8	1.0	1.0	0.9	1.0		
3.2. Урсгал шилжүүлэг	2,084,163.5	2,265,094.8	2,464,645.0	2,746,379.4	3,068,233.7	4,663,467.8	6,865,251.1	7,753,591.2	8,027,125.3	273,534.2	9.0	9.5	9.1	8.5	8.3	12.6	16.3	16.6	17.1		
B. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,396,704.6	2,360,210.2	1,658,140.7	1,680,430.2	3,016,672.2	3,034,235.9	4,906,738.5	5,197,135.7	5,197,135.7	0.0	6.0	9.9	6.1	5.2	8.2	8.0	11.1	10.5	10.5		
1. Барилга байгууламж	614,548.4	1,576,950.9	1,121,662.4	1,094,604.5	2,256,789.2	2,071,989.3	1,857,701.0	3,261,787.1	2,955,069.4	-306,717.8	2.7	6.6	4.1	3.4	6.1	5.6	4.4	7.0	6.3		
2. Их засвар	110,773.2	129,004.7	66,992.7	89,888.4	161,645.2	144,987.2	100,023.3	149,999.2	142,368.2	-7,630.9	0.5	0.5	0.2	0.3	0.4	0.4	0.2	0.3	0.3		
3. Тонго төхөөрөмж	73,837.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	452,574.9	342,438.5	353,976.3	11,537.8	0.3	0.0	0.0	0.0	0.0	1.1	0.7	0.8		
4. Бусад хөрөнгө	136,065.3	401,482.3	469,485.7	495,937.3	598,237.8	817,258.8	937,787.3	1,434,831.3	1,447,244.9	12,413.6	0.6	1.7	1.7	1.5	1.6	2.2	2.2	3.1	3.1		
5. Стратегийн нөөц хөрөнгө	27,829.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	15,429.7	8,079.7	0.0	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	433,650.6	252,772.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1.9	1.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
B. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЭЗЭЛ	22,895.4	521,313.6	316,016.2	286,451.7	416,449.8	41,110.9	-598,908.7	-264,600.1	-264,600.1	0.0	0.1	2.2	1.2	0.9	1.1	0.1	-1.4	-0.6	-0.6		
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-17,588.9	487,553.2	200,817.3	179,613.3	278,639.7	-119,522.0	-749,908.7	-544,600.1	-544,600.1	0.0	-0.1	2.0	0.7	0.6	0.8	-0.3	-1.8	-1.2	-1.2		
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	40,484.3	33,760.4	115,198.9	106,838.4	137,810.1	160,632.9	151,000.0	280,000.0	280,000.0	0.0	0.2	0.1	0.4	0.3	0.4	0.4	0.4	0.6	0.6		
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	-1,156,909.8	-3,660,289.1	-1,742,456.9	27,859.3	-756,190.0	-4,440,434.8	-3,691,837.1	-2,387,079.4	-2,387,079.4	0.0	-5.0	-15.3	-6.4	-0.1	-2.0	-12.0	-8.8	-5.1	-5.1		
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,156,909.8	3,660,289.1	1,742,456.9	-27,859.3	756,190.0	4,440,434.8	3,691,837.1	2,387,079.4	2,387,079.4	0.0	5.0	15.3	6.4	-0.1	2.0	12.0	8.8	5.1	5.1		
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-43,861.0	-112,351.4	-1,013,222.2	911,446.9	-1,103,376.9	1,868,413.0	123,036.8	-500,000.0	-500,000.0	0.0	-0.2	-0.5	-3.7	2.8	-3.0	5.1	0.3	-1.1	-1.1		
2. ЗГ-ын үнэт цаас	681,425.7	3,332,685.0	206,613.0	-2,434,728.6	-165,105.9	-249,393.2	2,258,612.6	1,371,318.6	1,401,318.6	30,000.0											

	2015		2016		2017		2018		2019		2020		2021		2022		Зөрүү
	Гуйц	Гуйц	Гуйц	Гуйц	Гуйц	Гуйц	Гуйц	Гуйц	Гуйц	Гуйц	Тод	Тод	Бат	Тод төс	Тод төс		
